



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 03

Мандалговь

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сайнцагаан сумын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хийгдсэн Айраг, Мандалын цэвэр усны шугамыг орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Айраг, Мандалын цэвэр усны шугамыг 28,469,484 /хорин найман сая дөрвөн зуун жаран есөн мянга дөрвөн зуун наян дөрөв/ төгрөгөөр нэмж үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэж авахыг Дундговь-Ус ОНӨҮГ-ын захирал Р.Энхмаад даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА



С.БУДЖАВ